**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 10 өдөр Дугаар А/62 Улаанбаатар хот

Онцгой байдлын байгууллагын
бэлэн байдлыг шалгаж, үнэлэх аргачлал
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 30 дугаар зүйлийн 30.1.5, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлыг шалгаж, үнэлэх аргачлал”-ыг нэгдүгээр, “Тайлан, мэдээ ирүүлэх загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан аргачлалыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, бэлэн байдлын үзлэгийг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж, шалгаж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ц.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

1426010680

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
А/162 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

# ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ШАЛГАЖ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

## Нэг. Зорилго

Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлыг тодорхой, үнэн зөв үнэлэх, үнэлгээ хийх ажлын хэсгүүдийн субьектив үнэлгээг бууруулж, нэгдсэн нэг шалгуур, арга зүйгээр үнэлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## Хоёр. Ерөнхий зохицуулалт

Энэхүү аргачлал нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/515 дугаар тушаалаар батлагдсан Гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамжийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлыг үнэлэх заавар”-ын 1.4-т заасан үнэлгээний хүснэгтийн тавигдах шаардлагын үзүүлэлтүүдийг тодорхой, нарийвчилсан байдлаар үнэлэхэд хэрэглэнэ.

## Гурав. Үнэлгээ хийх ерөнхий зарчим

3.1.Үнэлгээг ажлын хэсгээс боловсруулсан бодит байдалд дүйцүүлэн загварчилсан гамшиг, аюулт үзэгдэл, ослын цагийн байдалд тулгуурлана.

3.2.Үзүүлэлт тус бүрийг 0–100 хүртэлх хувиар үнэлж, тухайн заалтад хамаарах дэд шалгуур үзүүлэлтүүдийн арифметик дунджаар эцсийн хувийг тооцно.

3.3.Ажлын хэсэг тухайн газар, хэлтэс, салбар, нэгжийг үнэлэхдээ бүх салбар, нэгж, бүлэг, салаа, алба хаагчийг болон тэдгээрээс төлөөлүүлэн сонгож үзлэг шалгалт зохион байгуулж, нэгдсэн үнэлгээг гаргана.

3.4.Үнэлгээг хийхдээ дараах баримт, нотолгоог харгалзан үзнэ. Үүнд:

- Удирдлагын шийдвэр, захирамж;
- Штабын баримт бичиг, байр зүйн зургийн хөтлөлт;
- Төлөвлөгөө, схем, холбоо мэдээллийн бүртгэл;
- Тайлан, тэмдэглэл, судалгаа.

| Д/д | Ангилал | Тавигдах шаардлагын үзүүлэлт | | Үнэлэх аргачлал |
|---|---|---|---|---|
| А. Удирдлага, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний бэлэн байдал | | | | |
| 1 | А1. Удирдлага, зохион байгуулалтын бэлэн байдал | а | Гамшгийн үед үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зохих мэдлэг, дадлага эзэмшсэн, хууль эрх зүйн хүрээнд гамшгийн хариу арга хэмжээний шийдвэр гаргах чадвар | Ажлын хэсгийн ахлагч урьдчилан бэлдсэн гамшиг, аюулт үзэгдэл ослын цагийн байдлыг гардуулж ажиллуулан дараах байдлаар үнэлнэ. $$A1a = \frac{x + y}{2}$$ *x - хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах мэдлэг, дадлага эзэмшсэн байдал 100 хүртэл хувь;* *y - удирдлагын шийдвэр хууль, эрх зүйн баримт бичигт үндэслэсэн, нийцсэн, холбогдох эрх зүйн баримт бичгийг судалсан байдлыг 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ.* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | б | Гамшгийн хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилт, хүч хэрэгслийг оновчтой хуваарилж, мэдээ, мэдээлэл дамжуулах дараалллыг тогтоосон, шуурхай ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | Өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээг удирдан зохион байгуулж байгаа ур чадвар, шуурхай ажиллагааны төлөвлөлтийг оновчтой хийж, үр дүнтэй ашиглаж байгаа байдлыг үнэлж дүгнэнэ.<br>$A1б = \frac{x+y+z}{3}$<br>*x - Голомтын бүсэд хүч хэрэгслийг оновчтой хуваарилж удирдлага зохион байгуулалтыг шуурхай хэрэгжүүлж байгаа байдлыг 100 хүртэл хувь;*<br>*y-Шуурхай ажиллагааны төлөвлөгөөг оновчтой хийж үр дүнтэй ашиглаж байгаа байдалд 100 хүртэл хувь;*<br>*Z- Голомтын бүс, удирдлага, дээд шатны байгууллага, бусад байгууллагад мэдээлэл хүргэх дараалал, журмыг тогтоосон байдал 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ.* |
| | | в | Томилгоот болон дайчилгааны хүч хэрэгсэл, нөөцийг зөв оновчтой хуваарилах хувилбар, тооцоо, судалгаатай байдал | Хүч хэрэгсэл, нөөцийн хуваарилалт, тооцоо, судалгаа хийгдсэн, байдал I, II, III ээлжид үүрэг гүйцэтгэх томилгоо, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх боломжийг тус бүр 100 хүртэл хувиар үнэлнэ.<br>$A1в = \frac{f+s+d}{3}$<br>*f - I. II, III-р ээлжийн томилгоо гамшгийн төрөл тус бүрээр томилсон байх бөгөөд алба хаагчид гамшгийн төрлүүдэд давхардаж болно (100 хүртэл хувь);*<br>*s - I ээлжийн багаж, техник, хэрэгслийн хангалт болон II, III-р ээлжинд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний багаж, техник хэрэгслийн хангалтын хуваарилсан байдлыг харгалзан үзэж 100 хүртэл хувь;*<br>*d - алба хаагчдын томилгоотой танилцаж, үүргээ судалсан байдлыг шалгаж 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ* |
| | | г | Хүний нөөцийн нөхөн хангалтын хувь, үнэлгээ | Хүний нөөцийн нөхөн хангалтын хувийг гаргахдаа батлагдсан орон тоо болон тушаалаар томилогдсон алба хаагчдын нийлбэрийг хувьчлан гаргах бөгөөд үнэлгээнд тооцохгүй илтгэх хуудаст шалтгаан, нөхцөлийг тодорхой бичнэ.<br>$\text{Нөхөн хангалтын хувь} = \frac{а * 100}{б}$<br>а-тушаалаар томилогдсон алба хаагчийн тоо<br>б-батлагдсан орон тоо<br><br>Хүний нөөцийн бэлэн байдлыг үнэлэхдээ хүний нөөцийн нөхөн хангалтыг хийх талаар удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дээд шатны байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхээр гаргасан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | санал зэргийг үндэслэн 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| | | д | Томилгоот хүч хэрэгслийн бүх төрлийн хангалтыг зохион байгуулж, нэмэлтээр ажиллах бүрэлдэхүүнд бүх төрлийн хангалт (хоол, хүнс, ус, хамгаалах хувцас, шатахуун, дулаан байр) хийх бэлтгэлийг хангаж, санхүүгийн үйл явцын тодорхой хэмжээний мэдлэг, санхүүгийн нөөцийн мэдээлэлтэй байдал | Өгөгдсөн цагийн байдлын дагуу хариу арга хэмжээг зохион байгуулахдаа санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байгаа байдлыг харгалзан дараах байдлаар үнэлнэ. $$А1д = \frac{x + y + z}{3}$$ *x - Томилгоот хүч хэрэгслийг бүх төрлийн хангалтаар хангах тооцоо судалгаа, ар тал хангалт зохион байгуулсан байдлыг 100 хүртэл хувиар;* *y - Дайчилгааны хүч хэрэгслийг бүх төрлийн хангалтаар хангах боломж, хувилбар, нөхцөлийг тодорхойлсон байдлыг 100 хүртэл хувиар;* *z - Цагийн байдлын дагуу хариу арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан, цаашид шаардагдах санхүү, зардлын тооцоо гарсан, шийдвэрлүүлэх арга замыг тодорхойлсон, санал хүргүүлсэн бол 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ.* |
| | | е | Бие бүрэлдэхүүний ажил үүргээ гүйцэтгэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулсан байдал | ОБЕГ-ын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм", -ийн дагуу шалгаж үнэлнэ. *ОБЕГ-ын даргын 2023 оны А/338 дугаар тушаалын болон бусад хууль, дүрэм, журмын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 100 хүртэл хувиар.* |
| А1. Удирдлага, зохион байгуулалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | $$А1 = \frac{А1а + А1б + А1в + А1г + А1д + А1е}{6}$$ |
| 2 | А2. Бие бүрэлдэхүүн, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдал | а | Сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой хийж, бие бүрэлдэхүүний сургалт, дадлагыг зохион байгуулж үр дүнг тооцож хэвшсэн байдал | $$А2а = \frac{x + y}{2}$$ *x - алба хаагчдыг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх дадлагад тогтмол хамруулж, үр дүнг тооцсон байдалд 100 хүртэл хувь;* y- ОБЕГ-ын даргын 2025.05.21-ний өдрийн А/191 тушаал, *сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу алба хаагчдад сургалт зохион байгуулсан цаг, мэдлэгийн ахиц, үр дүнд 100 хүртэл хувиар тус тус тооцож үнэлнэ.* |
| | | б | Алба хаагчид бие бялдрын шалгуур үзүүлэлт, сэтгэл зүй болон эрүүл мэндийн шаардлагыг хангасан байдал | k- бие бялдрын шалгуур үзүүлэлт $$k = 100 - \frac{y * 100}{x}$$ *x – шалгалтад хамрагдсан бүрэлдэхүүний тоо;* *y - шалгуур үзүүлэлт хангаагүй алба хаагчийн тоо;* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | *100 – хувь.*<br>*Тайлбар: ЗХЖШ-ын даргын 2017 оны А/505 дугаар тушаалаар баталсан "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын дагуу норматив тус бүрээр авч, үр дүнг хувьд шилжүүлэн тооцож дундаж үзүүлэлтийг гарган үнэлнэ. Дасгалын гүйцэтгэлийг ЗХЖШ-ын даргын 2017 оны А/515 дугаар тушаалаар батлагдсан. "Цэргийн биеийн тамирын заавар ЦБТЗ-18"-ын дагуу шалгана.*<br><br>*b - алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэл. ОБЕГ-ыг 2025 оны А/496 дугаар тушаалаар баталсан "Онцгой байдлын албан хаагчдад сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар"-ын дагуу 100 хүртэл оноогоор тус тус үнэлнэ.*<br><br>d-эрүүл мэндийн шаардлага хангасан байдал<br>$$d = \frac{x + y + z}{3}$$<br>*x-эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байдал, баримт бичгийн бүрдэл 100 хүртэл хувь;*<br>*y-үзлэгт хамрагдсан хувь*<br>*z-өвчлөл өмнөх жилээс буурсан байдал (дараах байдлаар тогтооно)*<br>$$z = \frac{y * 100}{20}$$<br>*20- тогтмол тоо.*<br>*y-өмнөх жилээс буурсан өвчлөлийн хувь (өвчлөл буураагүй бол үнэлгээнд тооцож хувилахгүй);*<br>$$y = \frac{y1 * 100}{x} - \frac{y2 * 100}{x}$$<br>*x-үзлэгт хамрагдсан хүний тоо*<br>*y1-өмнөх жилд өвчлөлтэй гарсан хүний тоо*<br>*y2-тухайн жилд өвчлөлтэй гарсан хүний тоо*<br><br>Нийт алба хаагчдын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг бие бялдар, сэтгэл зүй, эрүүл мэндийн дундаж хувиар дараах байдлаар үнэлнэ.<br>$$A2б = \frac{k + b + d}{3}$$ |
| | | в | Эрхлэх албан тушаалын хүрээнд голомтыг бүсэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган үүрэг | Алба хаагчдыг өгөгдсөн цагийн байдалд ажиллуулж ослын голомтыг арилгахад багаж, техник, тоног төхөөрөмжөө ашиглаж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж байгаагаар үнэлнэ.<br>$$A2в = \frac{x + y}{2}$$<br>*x* – алба хаагчдын гүйцэтгэх мэргэжлийн мэдлэг, дадлага чадварт 100 хүртэл хувь; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэх мэдлэг чадвар, арга ажиллагаанд суралцсан эсэх | *у-* хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллаж байгаа байдал 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ *;*<br>Жич: ГТУА анги ОБЕГ-ын даргын 2022 оны А/300 дугаар тушаалаар баталсан Гал түймэр унтраах дасгал сургуулийн нормативын дагуу үнэлнэ. |
| | | г | Хариуцсан багаж, техник, тоног төхөөрөмжийг ашиглаж бүрэн эзэмшсэн, үзлэг, үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн байдал | Алба хаагчдыг өгөгдсөн цагийн байдалд ажиллуулж хариу арга хэмжээг зохион байгуулахад багаж, техник, тоног төхөөрөмжөө ашиглаж эзэмшсэн байдлыг үнэлнэ.<br>$А2г = 100 - \frac{у * 100}{x} \pm 10$<br>*x – шалгуулсан алба хаагчийн тоо;*<br>*у- хангалттай ажиллуулж чадаагүй алба хаагчийн тоо;*<br>*100 – хувь;*<br>*10-* шалгуулсан алба хаагчид хариуцсан багаж, техник хэрэгсэлдээ үзлэг, үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн байдлыг шалгаж 10 хүртэл хувь нэмж, хасна<br>Жич: ГТУА анги ОБЕГ-ын даргын 2022 оны А/300 дугаар тушаалаар баталсан Гал түймэр унтраах дасгал сургуулийн нормативын дагуу үнэлнэ. |
| | | д | Холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмжийг ашиглах, холбоо зохион байгуулах дараалал, журмыг сурч эзэмшсэн байдал | Алба хаагчдыг сонгон холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмжийг ашиглах, холбоо зохион байгуулалтыг гүйцэтгүүлж үнэлнэ.<br>$А2д = 100 - \frac{у * 100}{x}$<br>*x – шалгуулсан алба хаагчийн тоо;*<br>*у- хангалттай ажиллуулж чадаагүй алба хаагчийн тоо;*<br>*100 – хувь.* |
| | | е | Байгаль цаг уурын ямар ч нөхцөлд тохируулан үүрэг гүйцэтгэх хувийн бэлтгэлтэй байдал | $А2д = \frac{x + у}{2}$<br>*x – хээрийн үүргэвч, хувцас хэрэгслийг улирлын онцлогт тохируулан бэлтгэсэн байдалд 100 хүртэл хувь;*<br>*у – хариуцсан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг улирлын онцлогт тохируулан бэлэн байдлыг хангуулсан байдалд 100 хүртэл хувиар тус тус үнэлнэ.* |
| | | ё | Үүрэг гүйцэтгэхэд хугацаа алдалгүй бэлэн болж байгаа байдал | Ажлын хэсгийн ахлагч гамшиг, ослын цагийн байдлын дуудлага мэдээлэл өгч бэлэн болох хугацаа, хувийн бэлтгэл хангасан байдал, багаж, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрдэл, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болоход хугацаа алдаж байгаа байдал зэргийг харгалзан 100 хүртэл хувиар үнэлнэ.<br>Жич: Анги, салбар, нэгжийн бэлэн байдлыг алдагдуулахгүй байдлаар шалгалтыг зохион байгуулна. |
| А2. Бие бүрэлдэхүүн, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | $А2 = \frac{А2а + А2б + А2в + А2г + А2д + А2е + А2ё}{7}$ |

| Б. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц, хангалтын бэлэн байдал | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Б1. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бэлэн байдал | а | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтын бүртгэл, судалгаа, тооцоо, нөхөн хангалтын байдал | Монгол улсын стандарт MNS 6412:2025 "Гал түймэр унтраах аврах анги, салбарт тавих шаардлага", Монгол Улсын стандарт MNS 6740:2015 "Онцгой байдлын байгууллагын эрэн хайх аврах нэгжид тавих шаардлага"-д заасан техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл тус бүрээр эрэн хайх аврах, гал түймэр унтраах анги, салбаруудын одоо байгаа хангалтыг хувьчлан гаргаж нөхөн хангалтын хувийг гаргаж үнэлгээнд тооцохгүй бөгөөд илтгэх хуудсанд шалтгаан, нөхцөлийг тодорхой бичнэ.<br>$$a = \frac{x * 100}{y}$$<br>*а*- нөхөн хангалтын хувь;<br>*х - одоо багаа техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо;*<br>*у - стандартад заасан техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо.*<br><br>Ажлын хэсэг нөхөн хангалтыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтын бүртгэл, судалгаа, тооцоо, хуваарилалт, ашиглалтын байдлыг шалгаж 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| | | б | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээг тухай бүр тогтмол хийсэн байдал | Эвдрэл, гэмтэлтэй байгаа сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо, засвар үйлчилгээ хийсэн байдал, засварлуулахаар хэрэгжүүлсэн арга хэмжээг харьцуулан үнэлнэ. (Дахин ашиглах боломжгүй болоод акталсан, актлуулахаар санал хүргүүлсэн бол тооцохгүй)<br>b- Эвдрэл, гэмтэлтэй байгаа, сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн машин, техник, механизмын тоо<br>$$b = \frac{y * 100}{x}$$<br>*х - эв*дрэл, гэмтэлтэй байгаа болон сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн машин, техник, механизмын тоо<br>*у - засвар хийсэн* машин, техник, механизмын тоо<br><br>d- Эвдрэл, гэмтэлтэй байгаа, сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо<br>$$d = \frac{y * 100}{x}$$<br>*х - эв*дрэл, гэмтэлтэй байгаа болон сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо<br>*у-засвар хийсэн* тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | $$3б = \frac{\mathrm{b} + \mathrm{d}}{2}$$ Тайлбар: Гал түймэр унтраах аврах ангиас бусад нэгжийг дээрх үзүүлэлтээр шалгана. Гал түймэр унтраах, аврах анги ОБЕГ-ын даргын 2023 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар"-ын дагуу хийсэн ажлыг үнэлнэ. |
| | | в | Алба хаагчид аврах ажлын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байдал | Томилгоот бүлэг батлагдсан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байдал, хангалтыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, орон нутгийн онцлогт тохирсон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг судалж, хангуулах талаар дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байдалд 100 хүртэлх хувиар дүгнэнэ. |
| | | г | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үүрэг гүйцэтгэх найдвартай ажиллагаа | Ашиглагдаж байгаа нийт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоог эвдрэл, гэмтэлтэй багаж, техник, тоног төхөөрөмжтэй харьцуулан тооцно. (Дахин ашиглах боломжгүй болоод акталсан, актлуулахаар санал хүргүүлсэн бол тооцохгүй)<br>b.нийт эвдрэл гэмтэлтэй машин техникийн эзлэх хувь $$\mathrm{b} = 100 - \frac{y * 100}{x}$$ *x- нийт машин техникийн тоо*<br>*y-эвдрэл, гэмтэлтэй машин техникийн тоо*<br>d.нийт эвдрэл гэмтэлтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн эзлэх хувь $$d = 100 - \frac{y * 100}{x}$$ x- нийт тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо<br>y-эвдрэл, гэмтэлтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо $$3г = \frac{\mathrm{b} + \mathrm{d}}{2} \pm 10$$ г- Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүртгэл тооцоо, судалгаа, паспорт хөтлөлт (10 хүртэл оноог ажлын хэсэг нэмж, хасна). |
| Б1. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | $$Б1 = \frac{Б1а + Б1б + Б1в + Б1г}{4}$$ |
| 4 | Б.2. Холбоо, зохион байгуулалтын бэлэн байдал | а | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг шуурхай | Газар, хэлтэс, анги, салбарт өдөр тутмын болон гамшгийн мэдээ мэдээллийг хүлээн авах дамжуулах суурь бүтэц бүрдсэн (ОБЕГ-ын даргын 2025 оны А/447 дугээр тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжийн холбооны техник хэрэгсэлд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дамжуулах дараалал, журмыг тогтоосон байдал | тавигдах ерөнхий шаардлага" стандартыг Хүснэгт 13-т тусгасан шаардлага) хангасан байдлыг 100 хүртэл хувиар үнэлнэ. Үүнд:<br>$$\text{Б2а} = \frac{x + y + z + b + d}{5} \pm 10$$<br>x-Суурин болон хөдөлгөөнт интернэт, мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмжийн ашиглалт, бэлэн байдалд 100 хүртэл хувь:<br>y-Утсан холбооны ашиглалт, бэлэн байдалд 100 хүртэл хувь;<br>z-Хөдөлгөөнт холбоо (радио холбоо, сансрын холбоо)-ны ашиглалт, бэлэн байдалд 100 хүртэл хувь;<br>d-Байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа мэдээллийн систем, лицензтэй программ хангамжуудын ашиглалт;<br>d-Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, бэлэн байдал 100 хүртэл хувь<br>10-Дрон, энгэрийн камер, нөөц цахилгаан үүсгүүр (UPS, генератор) ашигладаг бол ажлын хэсгээс 10 хүртэл оноог нэмж, хасаж тооцно |
| | | б | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авах, шуурхай дамжуулах зориулалт бүхий харилцаа холбооны төрөл бүрийн техник, тоног төхөөрөмж, программ хангамжаар хангагдаж, шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байдал | ОБЕГ-ын даргын 2024 оны А/429 дүгээр тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжийн холбооны техник хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" стандартын дагуу хангалтын хувийг гаргаж үнэлгээнд тооцохгүй бөгөөд илтгэх хуудсанд шалтгаан, нөхцөлийг тодорхой бичнэ<br>$$\text{Б2б} = \frac{\text{x} * 100}{\text{y}}$$<br>*x - одоо байгаа харилцаа холбооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо*<br>*y - стандартад заасан харилцаа холбооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо*<br>*(Жич: Зөвхөн радио холбоо, сансрын холбооны хангалтын хувь тооцогдоно.)*<br><br>Томилгоот бүлэг нь гамшгийн голомтод ашиглах хөдөлгөөнт радио станц (гар, машины, үүргэвчийн) болон сансрын холбооны тоног хангалтын хувийг дээшлүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тооцоо судалгаа, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулсан санал зэргийг харгалзан 100 хүртэлх хувиар дүгнэнэ. |
| | | в | Холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмж, программ | b.Эвдэрч гэмтсэн харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжийн тоо<br>$$b = \frac{y * 100}{x}$$ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хангамжийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж, найдвартай ажиллагааг хангасан байдал | *x - эвдрэл, гэмтэлтэй байгаа болон сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн харилцаа холбооны техник, тоног төхөөрөмж (радио холбоо, сансрын холбоо, үүрэн холбоо, зарлан мэдээлэл болон бусад)-ийн тоо*<br>*у - засвар хийсэн харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжийн тоо*<br><br>d.Эвдэрч гэмтсэн мэдээлэл технологийн техник хэрэгсэл (компьютер, программ хангамж, тоног, төхөөрөмж)-ийн тоо<br>$$\mathrm{d} = \frac{y * 100}{x}$$<br>*x - эвдрэл, гэмтэлтэй байгаа болон сүүлийн 1 жилд эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо*<br>*у - засвар хийсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо*<br><br>s.Бүртгэл, ашиглалтын удирдлага<br><br>- Техник, тоног төхөөрөмжийн бүртгэлийн нэгдсэн сан, эдэлгээ норм, норматив, ашиглалтын хугацааг тооцсон байдал, нөхөн хангалтын судалгаа, төлөвлөлт, техник ашиглалтын паспорт хөтлөлтийн байдлыг үнэлж 100 хүртэл хувиар үнэлнэ.<br>$$\text{Б2в} = \frac{\mathrm{b} + \mathrm{d} + \mathrm{s}}{3}$$ |
| | | г | Холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байдал | Кибер аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг хангасан байдлыг 100 хүртэл хувиар үнэлнэ; |
| | | д | Бусад холбогдох хуулийн этгээдтэй холбоо зохион байгуулах нөхцөлөөр хангагдсан байдал (ОБЕГ-ын дэргэдэх анги, салбарт хамаарахгүй) | $$\text{Б2а} = \frac{\mathrm{x} + \mathrm{y} + z + \mathrm{c}}{4}$$<br>X-төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай холбоо зохион байгуулах бэлэн байдал 100 хүртэл хувь;<br>Y-аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой комисстой холбоо зохион байгуулах бэлэн байдал 100 хүртэл хувь;<br>z- гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэгтэй холбоо зохион байгуулах бэлэн байдал 100 хүртэл хувь;<br>c-дайчлагдан гарахаар томилогдсон иргэн, хуулийн этгээдтэй холбоо зохион байгуулах бэлэн байдал. |
| Б2. Холбоо, зохион байгуулалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | $$\text{Б2} = \frac{\text{Б2а} + \text{Б2б} + \text{Б2в} + \text{Б2г} + \text{Б2д}}{5}$$ |
| 5 | Б3. Нөөц, хангалтын бэлэн байдал | а | Голомтод үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлэгт шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцас, шатах тослох | ОБЕГ-ын даргын 2023 оны А/392 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын ар тал, хангалтын журам”, “Ар тал, хангалтын үйл ажиллагааны бүдүүвч”-ийн дагуу үнэлж дүгнэнэ.<br>$$\text{Б3а} = \frac{\mathrm{x} + \mathrm{y} + z + \mathrm{c}}{4} \pm 10$$ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | материал болон бусад нөөцийг бүрдүүлсэн байдал | *x - нийт алба хаагчийн нормын хувцас, хэрэгслийн хангалтын хувь;*<br>*y - томилгоот техник, хэрэгслийн шатахууны хангалт, дүүргэлтийн хувь;*<br>*z - томилгоот бүрэлдэхүүний хоол хүнсний хангалтын хувь;*<br>*c - хангалт зохион байгуулсан арга хэмжээ. Ажлын хэсгийн ахлагч санхүүгийн чадамж, хангалтын нөөцийг харгалзан ±10 хүртэл оноог нэмж эсхүл хасаж болно.* |
| | | б | Тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байдал | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, орон нутгийн онцлогт тохируулан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөц бүрдүүлсэн, орон нутгийн болон бусад эх үүсвэрээс нэмэлтээр техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хангах арга хэмжээг зохион байгуулсан байдалд 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| | | в | Нөөц хүч, хэрэгслийн бүртгэл, судалгааг гаргаж хөтөлсөн байдал | Нөөц хүч, хэрэгслийн бүртгэл, судалгааг гаргаж хөтөлсөн байдал, хадгалалт, аюулгүй байдлыг хангасан байдалд 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| Б3. Нөөц, хангалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | $Б3 = \frac{Б3а + Б3б + Б3в}{3}$ |
| В.Нэмэлт шалгуур үзүүлэлт | | | | |
| д/д | Ангилал | | Тавигдах шаардлагын үзүүлэлт | Үнэлэх аргачлал |
| 6 | В1 Удирдлагын байр | а | Байнгын болон нөөц удирдлагын байрыг тоноглосон байдал, техник хэрэгслийн хангалтын байдал | b.Байрыг томилгоожуулсан байдал 1.Байнгын удирдлагын байр, 2. нөөц удирдлагын байр, 3. Хээрийн суурин удирдлагын байр, 4. хээрийн хөдөлгөөнт удирдлагын байрыг даргын тушаалаар томилгоожуулсан байдалыг үнэлж 100 хүртэл оноогоор үнэлнэ;<br>$b = \frac{x * 100}{4}$<br>*4- нийт томилгоожуулах байрны тоо;*<br>x *-тушаалаар томилгоожуулсан байрны тоо.*<br><br>*d.*Техник хэрэгслийн хангалт /Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/147 дугаар тушаалаар баталсан "Шуурхай ажиллагаа зохион байгуулах журам" хавсралт 6 дугаар хүснэгтийн дагуу үнэлнэ/-ыг хүснэгтэд заасан иж бүрдлийн хэдэн хувийг хангаж байгааг тооцон 100 хүртэлх оноогоор үнэлнэ;<br>$d = \frac{x * 100}{26}$<br>*x-байнгын удирдлагын байранд байгаа иж бүрдлийн тоо (ОБЕГ-ын даргын 2024 оны А/147 дугаар тушаалын 6-р хавсралтад заасан иж бүрдлээс одоо байгаа тоо);*<br>*26-А/147 дугаар тушаалын хавсралт 6-р хүснэгт заасан иж бүрдлийн тоо.* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | *Дээрх үзүүлэлтийн дундаж оноогоор үнэлнэ.*<br>$$B1а = \frac{b + d}{2}$$ |
| | | б | Хээрийн хөдөлгөөнт удирдлагын байр, түүний хээрийн бэлэн байдал (хүнс, усны хангалт, шатахууны нөөцийн байдал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал) | Хээрийн удирдлагын суурин болон Хөдөлгөөнт удирдлагын байрыг төхөөрөмжилсөн байдал /Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/147 дугаар тушаалаар баталсан "Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам"-ын 6, 8 дугаар хүснэгтийн дагуу иж бүрдлийн хэдэн хувийг хангаж байгааг тооцон 100 хүртэлх оноогоор үнэлнэ.<br>$$B1б = \frac{(x + y) * 100}{35}$$<br>*x - ОБЕГ-ын даргын 2024 оны А/147дугаар тушаалын 6 дугаар хүснэгтэд заасан бүрдлээс одоо байгаа тоо;*<br>*y - 8 дугаар хүснэгтийн дагуу бүрдүүлсэн тоо;*<br>*35 - А/147 дугаар тушаалын 6, 8-р хүснэгтэд заасан иж бүрдлийн тоо.* |
| 7 | B2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, төлөвлөлт | а | Гамшгаас хамгаалах хүн, хүч хэрэгслийн бэлэн байдал (алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, томилгоот бүрэлдэхүүн) (ОБЕГ-ын дэргэдэх анги, салбарт хамаарахгүй.) | ОБЕГ-ын даргын 2023 оны А/383 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг шалгалт явуулах, үнэлэх журам"-ын дагуу Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан шалгалтаар үнэлэгдсэн үнэлгээ, алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн томилгоо, тэдгээрийн тодотгож, танилцуулсан байдлыг төлөөлүүлэн утсаар болон бусад хэлбэрээр шалгаж 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| | | б | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүний боловсруулалт, хэрэгжилт | b. Бэлэн байдлыг шалгах, бэлэн байдлыг хангах, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулсан байдлаар үнэлж дүгнэнэ.<br>$$b = \frac{x * 100}{y}$$<br>*x – Төлөвлөгөөний биелэлтийн хувь;*<br>*y – нийт төлөвлөсөн ажлын тоо.*<br><br>d.МУ-ын Шадар сайдын 2018 оны "Заавар батлах тухай" 120 дугаар тушаалаар тухайн орон нутаг, алба, мэргэжлийн ангид Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж батлуулсан тоо, тухайн жилд төлөвлөгөөг тодотгосон тоог харьцуулж үнэлгээг гаргана.<br>$$d = \frac{(x + y) * 100}{z}$$<br>*x – тухайн жил хянаж батлуулсан төлөвлөгөөний тоо;*<br>*y – тухайн жилд тодотгосон төлөвлөгөөний тоо;* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | *z – нийт төлөвлөгөөний тоо /батлагдсан тушаал шийдвэрийг үндэслэн тооцно/.*<br>*Нийт үнэлгээг дараах байдлаар тооцно.*<br>$B2a = \frac{b+d}{2}$ |
| 8 | В3.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг | а | Албаны байнгын бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт | ОБЕГ-ын даргын 2025 оны А/515 дугаар тушаалаар баталсан "Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж"-ийн 5 дугаар бүлгийн 5.5 хэсгийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлаар тооцон гаргана.<br>$8a = \frac{x+y}{2}$<br>x – ОБЕГ-ын даргын 2025 оны А/515 дугаар тушаал баталсан "Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж"-ийн 5 дугаар бүлгийн 5.5 хэсгийн 5.5.1 заалтын дагуу шалгаж 100 хүртэл хувь;<br>у - ОБЕГ-ын даргын 2025 оны А/515 дугаар тушаал баталсан "Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж"-ийн 5 дугаар бүлгийн 5.5 хэсгийн 5.5.2 заалтын дагуу шалгаж 100 хүртэл хувь;<br>2 - ОБЕГ-ын даргын 2025 оны А/515 дугаар тушаал баталсан "Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж"-ийн 5 дугаар бүлгийн 5.5 хэсгийн 5.5.1, 5.5.2 заалтын тоо. |
| | | б | Албаны өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлтгэл | ОБЕГ-ын даргын 2025 оны А/515 дугаар тушаалаар баталсан "Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж"-ийн 5 дугаар бүлгийн 5.6 хэсгийн арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлыг 100 хүртэл хувиар үнэлнэ. |
| 9 | В4. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаа | а | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүн, хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө | *В4а - дайчлан гаргах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байдалд 100 хүртэл хувь;*<br>*В4б - дайчлагдан ажиллах хүн техникийн тооцоотой байдалд 100 хүртэл хувь;*<br>*В4в - бэлтгэл бэлэн байдлыг хангуулахаар хэрэгжүүлсэн ажлуудын дунджийг 100 хүртэл хувь тус тус дүгнэнэ.*<br>*Нийт үнэлгээг дараах байдлаар тооцно.*<br>$B4 = \frac{B4a + B4б + B4в}{3}$ |
| | | б | Дайчлан гаргах хүн хүч, багаж, техник, материал хэрэгслийн тооцоо, судалгаа | |
| | | в | Дайчлагдан ажиллах хүч хэрэгслийн бэлэн байдал | |
| 10 | В5. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | а | Хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр | *В5а – хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, түр байрлуулах байрны судалгааг гарган батлуулсан байдалд 100 хувь;*<br>*В5б - түр цугларах аюулгүйн талбайг томилгоожуулсан байдалд 100 хувь;* |
| | | б | Түр цугларах талбай | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | в | Нисдэг тэрэг нисэх, буух, хөөрөх газрыг тодорхойлж, төхөөрөмжилсөн байдал | *В5в - нисдэг тэрэг буух, хөөрөх зурвасыг тодорхойлж томилгоожуулсан байдалд 100 хувь тус тус дүгнэнэ.*<br>*Нийт үнэлгээг дараах байдлаар тооцно.*<br>$В5 = \frac{В5а + В5б + В5в}{3}$ |
| В.Нэмэлт шалгуур | | | | $В = \frac{В1 + В2 + В3 + В4 + В5}{5}$ |
| Нэгдсэн дүн | | | | $Нэгдсэн\ дүн = \frac{А1 + А2 + Б1 + Б2 + Б3 + В}{6}$ |

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
А/... дугаар тушаалын 12 дугаар хавсралт
/62

ТАЙЛАН, МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ЗАГВАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА
ИЛТГЭХ ХУУДАС
Бэлэн байдлын үзлэг шалгалт зохион байгуулсан тухай

2026.03./.../ .......... сум

Нэг. Удирдлага зохицуулалт

Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2026 оны ... дугаар сарын ..-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ... аймгийн Онцгой байдлын газрын бэлэн байдлын үзлэг шалгалтыг ... дугаар сарын ...-...-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Хоёр. Үзлэг, шалгалт зохион байгуулсан талаар

“Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамж”-ийн дөрөвдүгээр бүлэгт заасан ангиллын дагуу үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, ололтой талыг товч, тодорхой бичнэ.

Гурав. Санал, дүгнэлт

Бэлэн байдлын үзлэг шалгалт зохион байгуулсан тухай дүгнэлт, цаашид бэлэн байдлыг хангах, дээшлүүлэх талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тодорхой тусгана.

Дөрөв. Бэлэн байдлын үзлэг шалгалт зохион
байгуулсан зурагт тайлан.

Зургаар баталгаажуулсан байна.

Хавсралтад батлагдсан удирдамж, дүнгийн хуудас, зөрчил дутагдлын тайлбар зэрэг баримт бичиг хавсрагдана.

ТАНИЛЦСАН:
ДАРГА,
цол гарын үсэг нэр

ХЯНАСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА, албан тушаал
цол гарын үсэг нэр

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ, албан тушаал
цол гарын үсэг нэр

# ..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГИЙН ДҮНГИЙН ХҮСНЭГТ

2026...... ...... сум

| д/д | Ангилал | | Тавигдах шаардлагын үзүүлэлт | Шаардлага тус бүрийн үнэлгээ (хувь) |
|---|---|---|---|---|
| А. Удирдлага, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний бэлэн байдал | | | | |
| 1 | А1. Удирдлага, зохион байгуулалтын бэлэн байдал | а | Гамшгийн үед үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зохих мэдлэг, дадлага эзэмшсэн, хууль эрх зүйн хүрээнд гамшгийн хариу арга хэмжээний шийдвэр гаргах чадвар | |
| | | б | Гамшгийн хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилт, хүч хэрэгслийг оновчтой хуваарилж, мэдээ, мэдээлэл дамжуулах дарааллыг тогтоосон, шуурхай ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | |
| | | в | Томилгоот болон дайчилгааны хүч хэрэгсэл, нөөцийг зөв оновчтой хуваарилах хувилбар, тооцоо, судалгаатай байдал | |
| | | г | Хүний нөөцийн нөхөн хангалтын хувь, үнэлгээ | |
| | | д | Томилгоот хүч хэрэгслийн бүх төрлийн хангалтыг зохион байгуулж, нэмэлтээр ажиллах бүрэлдэхүүнд бүх төрлийн хангалт (хоол, хүнс, ус, хамгаалах хувцас, шатахуун, дулаан байр) хийх бэлтгэлийг хангаж, санхүүгийн үйл явцын тодорхой хэмжээний мэдлэг, санхүүгийн нөөцийн мэдээлэлтэй байдал | |
| | | е | Бие бүрэлдэхүүний ажил үүргээ гүйцэтгэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулсан байдал | |
| А1. Удирдлага, зохион байгуулалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | |
| 2 | А2. Бие бүрэлдэхүүн, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдал | а | Сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой хийж, бие бүрэлдэхүүний сургалт, дадлагыг зохион байгуулж үр дүнг тооцож хэвшсэн байдал | |
| | | б | Алба хаагчид бие бялдрын шалгуур үзүүлэлт, сэтгэл зүй болон эрүүл мэндийн шаардлагыг хангасан байдал | |
| | | в | Эрхлэх албан тушаалын хүрээнд голомтыг бүсэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаан үүрэг гүйцэтгэх мэдлэг чадвар, арга ажиллагаанд суралцсан эсэх | |
| | | г | Хариуцсан багаж, техник, тоног төхөөрөмжийг ашиглаж бүрэн эзэмшсэн, үзлэг, үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн байдал | |
| | | д | Холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмжийг ашиглах, холбоо зохион байгуулах дараалал, журмыг сурч эзэмшсэн байдал | |
| | | е | Байгаль цаг уурын ямар ч нөхцөлд тохируулан үүрэг гүйцэтгэх хувийн бэлтгэлтэй байдал | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ё | Үүрэг гүйцэтгэхэд хугацаа алдалгүй бэлэн болж байгаа байдал | |
| А2. Бие бүрэлдэхүүн, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | |
| Б. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц, хангалтын бэлэн байдал | | | | |
| 3 | Б1. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал | а | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтын бүртгэл, судалгаа, тооцоо, нөхөн хангалтын байдал | |
| | | б | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээг тухай бүр тогтмол хийсэн байдал | |
| | | в | Алба хаагчид авах ажлын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байдал | |
| | | г | Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үүрэг гүйцэтгэх найдвартай ажиллагаа | |
| Б1. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | |
| 4 | Б.2. Холбоо, зохион байгуулалтын бэлэн байдал | а | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах дараалал, журмыг тогтоосон байдал | |
| | | б | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авах, шуурхай дамжуулах зориулалт бүхий харилцаа холбооны төрөл бүрийн техник, тоног төхөөрөмж, програм хангамжаар хангагдаж, шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байдал | |
| | | в | Холбоо, мэдээллийн техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж, найдвартай ажиллагааг хангасан байдал | |
| | | г | Холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байдал | |
| | | д | Бусад холбогдох хуулийн этгээдтэй холбоо зохион байгуулах нөхцөлөөр хангагдсан байдал | |
| Б2. Холбоо, зохион байгуулалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | |
| 5 | Б3. Нөөц, хангалтын бэлэн байдал | а | Голомтод үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлэгт шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцас, шатах тослох материал болон бусад нөөцийг бүрдүүлсэн байдал | |
| | | б | Тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байдал | |
| | | в | Нөөц хүч, хэрэгслийн бүртгэл, судалгааг гаргаж хөтөлсөн байдал | |
| Б3. Холбоо, зохион байгуулалтын бэлэн байдлын дундаж үнэлгээ | | | | |
| д/д | Ангилал | Тавигдах шаардлагын үзүүлэлт | | Оноо |
| 6 | В1. Удирдлагын байр | а | Байнгын болон нөөц удирдлагын байрыг тоноглосон байдал, техник хэрэгслийн хангалтын байдал | |
| | | б | Хээрийн хөдөлгөөнт удирдлагын байр, түүний хээрийн бэлэн байдал (хүнс, усны хангалт, шатахууны нөөцийн байдал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал) | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | В2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, төлөвлөлт | а | Гамшгаас хамгаалах хүн, хүч хэрэгслийн бэлэн байдал (алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, томилгоот бүрэлдэхүүн) | |
| | | б | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүний боловсруулалт, хэрэгжилт | |
| 8 | В3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг | а | Албаны байнгын бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт | |
| | | б | Албаны өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний бэлтгэл | |
| 9 | В4. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаа | а | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүн, хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө | |
| | | б | Дайчлан гаргах хүн хүч, багаж, техник, материал хэрэгслийн тооцоо, судалгаа | |
| | | в | Дайчлагдан ажиллах хүч хэрэгслийн бэлэн байдал | |
| 10 | В5. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | а | Хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр | |
| | | б | Түр цугларах талбай | |
| | | в | Нисдэг тэрэг нисэх, буух, хөөрөх газрыг тодорхойлж, тохижуулсан байдал | |
| В.Нэмэлт шалгуурын дундаж үнэлгээ | | | | |
| Нэгдсэн дүн | | | | |

---oOo---